



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар

7/503

Арвайхээр

Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед ажиллах тохиолдлын удирдлагын тогтолцооны баг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын “Журам батлах тухай” 2017 оны 08 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед ажиллах тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

3.Үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тооцон, нөөц бүрдүүлж, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагын санхүүч, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101123

Аймгийн Засаг даргын 2020 оны
.11... дүгээр сарын .13.-ны өдрийн А/503
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**БОЛЗОШГҮЙ ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ
БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД АЖИЛЛАХ ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН
ТОГТОЛЦООНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Тохиолдлын удирдлагын тогтолцооны баг нь зохицуулагч, менежер, төлөвлөлтийн баг, хариу арга хэмжээний баг, эрсдэлийн мэдээлэл харилцааны баг, санхүү нөөцийн багаас бүрдэнэ.

Зохицуулагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга
Менежер: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Нэг. Төлөвлөлтийн баг

Багийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
-Аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга
-Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга
-Аймгийн Цагдаагийн газрын дэд дарга бөгөөд Эрүүгийн тасгийн дарга
-Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга
-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
-Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, аж ахуйн дарга
-Тагнуулын ерөнхий газрын Өвөрхангай аймаг дахь Тагнуулын хэлтсийн ахлах ажилтан, дэд хурандаа
-Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Гамшиг, яаралтай тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Хариу арга хэмжээний баг

Багийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Гишүүд: -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
-Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч
-Зоонозын өвчин судлалын төвийн дарга
-Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч
-Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журмын тасгийн дарга
-Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

Гурав. Эрсдэлийн мэдээлэл харилцааны баг

Багийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Гишүүд: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн

2.

- боловсрол, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Олон нийттэй харилцах ажилтан
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Мэдээлийн технологийн мэргэжилтэн
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн
 - Аймгийн Онцгой байдлын газрын Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Аймгийн Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Зоонозын өвчин судлалын төвийн биологич

Дөрөв. Санхүү, нөөцийн баг

Багийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ерөнхий санхүүч

- Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын эдийн засагч
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч
 - Аймгийн Онцгой байдлын газрын ахлах нягтлан бодогч
 - Аймгийн Цагдаагийн газрын нягтлан бодогч
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын нягтлан бодогч
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс хөдөө аж ахуйн газрын хүнсний хангамж хариуцсан мэргэжилтэн

-oOo-

Аймгийн Засаг даргын 2020 оны
11... дүгээр сарын 13...-ны өдрийн А/503
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БАГИЙН АЖИЛЛАХ ЧИГ

Нэг. Зохицуулагч, менежерийн үүрэг:

1.1. Зохицуулагчийн үүрэг:

- 1.1.1. Зохицуулагч нь үйл явдлын төрлөөс хамаарч баг, бүрэлдэхүүнийг томилох;
- 1.1.2. Менежерийг чиглүүлж, бодлогын дэмжлэг үзүүлэх;
- 1.1.3. Төлөвлөлт, санхүү, хариу арга хэмжээний гаргасан төлөвлөгөө, шаардлагатай төсвийн тооцоог аймаг, орон нутгийн удирдлага, онцгой комисст танилцуулж, бэлэн байдлыг хангах нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 1.1.4. Менежертэй гадаад, дотоодын санхүүгийн болон техникийн тусламжийн талаар зөвлөлдөж, төсөв, санхүү, нөөцийг шийдвэрлэх;
- 1.1.5. Байгууллага, нэгжийг идэвхжүүлэх, идэвхжлийн зэргийг өөрчлөх, цуцлах шийдвэр гаргах, цуцалсныг зарлах;
- 1.1.6. Эрсдэлийн мэдээлэл харилцааны үйл ажиллагааг чиглүүлэх;
- 1.1.7. Үйл явдлын талаарх албан ёсны мэдээллийг олон нийтэд хүргэх;

1.2. Менежерийн үүрэг:

- 1.2.1. Тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөж, удирдан зохион байгуулах;
- 1.2.2. Багийн ахлагч нарыг үүрэгжүүлэх, удирдан чиглүүлэх, хяналт тавих;
- 1.2.3. Багийн үүрэг, хариуцлагыг тодорхойлж, гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;
- 1.2.4. Багийг хүний нөөцөөр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- 1.2.5. Эрсдэлийн мэдээллээ, харилцаа, хэвлэлийн тоймыг хянан баталгаажуулах;
- 1.2.6. Шуурхай хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- 1.2.7. Хүний нөөц, санхүүгийн болон техникийн дэмжлэг авах талаар зохицуулагчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;
- 1.2.8. Үйл ажиллагааны тайланг хянаж, зохицуулагчид танилцуулах;

Хоёр. Төлөвлөлт, хяналтын багийн ажиллах чиг үүрэг:

- 2.1. Хариу арга хэмжээний төлөвлөгөөг салбар хоорондын байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулах;
- 2.2. Бусад багийн ахлагч нартай хамтран төсөв, төлөвлөлт хийх;
- 2.3. Мэдээлэлд тандалт, дүн шинжилгээ, эрсдэлийн нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээ хийх;
- 2.4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, дадлага сургуулилтын дүгнэлтэд тулгуурлан шуурхай боловсруулан баталгаажуулах, тодотгол хийх;
- 2.5. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын идэвхжлийн үед гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үндэслэн үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг 7 хоногоор боловсруулан, баталгаажуулж, хэрэгжилтийг хянах;
- 2.6. Төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг менежерээр дамжуулан өдөр тутам авах;

2.

- 2.7. Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг батлагдсан аргачлалд тулгуурлан тооцоолох холбогдох багуудыг тооцоолол бүхий мэдээллээр хангах;
- 2.8. Хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянан мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 2.9. Сургамж, дүгнэлт, санал бүхий тайлан гаргаж, 7 хоног бүр менежерт хүргүүлэх;

Гурав. Хариу арга хэмжээний багийн ажиллах чиг үүрэг:

- 3.1. Хариу арга хэмжээний төлөвлөгөөг салбар хоорондын байгууллагуудтай хамтран боловсруулж батлуулах;
- 3.2. Хамтарсан хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- 3.3. Хариу арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах;
- 3.4. Голомтыг цомхотгох, таслан зогсоох арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоох саналыг зохицуулагчид хүргүүлэх;
- 3.5. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын өдөр тутмын бэлэн байдлыг хангуулах, мэдээллээр хангах;
- 3.6. Коронавируст халдвар(COVID-19)-аас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний талаарх өдөр тутмын мэдээллийг бэлтгэж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- 3.7. Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг зохион байгуулах, лабораторийн оролцоог хангах;
- 3.8. Шаардлагатай нөөцийн судалгааг гаргаж төлөвлөлт болон санхүү, нөөцийн багт хүргүүлэх;
- 3.9. Сургамж, дүгнэлт, санал бүхий тайлан гаргаж, 7 хоног бүр менежерт хүргүүлэх;

Дөрөв. Эрсдэлийн мэдээлэл, харилцаа холбооны багийн ажиллах чиг үүрэг:

- 4.1. Хүн амын дундах мэдээлэл, мэдлэгийн түвшинг тогтоох судалгаа хийх, мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- 4.2. Коронавируст халдвар (COVID-19)-ын халдварын тархалт, цаг үеийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг цаг тухайд нь идэвхжлийн түвшин өөрчлөгдөх бүрт шинэчлэн боловсруулж, хүн амд шууд хүргэх оновчтой хувилбараар түгээх;
- 4.3. Томилогдсон албан тушаалтан, мэргэжилтнийг мэдээллээр хангаж, олон нийтэд хандаж мэдээлэл хийлгэх ажлыг зохион байгуулах;
- 4.4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, мониторинг хийж, цаашдын стратегийг боловсруулах;
- 4.5. Үүссэн нөхцөл байдалтай холбоотой олон нийтийн санаа бодлыг сонсох, иргэдэд тулгамдаж байгаа асуудлын талаар шуурхай хариулт өгөх, мэдээлэл цуглуулах, судалгаа, дүгнэлт хийх, эргэн мэдээлэх, асуудлаа зөв шийдвэрлэхэд нь бодит дэмжлэг болохуйц (төлбөргүй лавлах утас, нээлттэй утас г.м) үйлчилгээг бий болгох, шуурхай утасны дугаарыг олон нийтэд зарлаж, тогтмол ажиллуулах;
- 4.6. Хэвлэлийн бага хурал, цахим хурал, сургалт зохион байгуулж, хүн амыг нэгэн зэрэг тодорхой мэдээллээр хангах;
- 4.7. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй бүхий л мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг багийн бүх гишүүдэд өдөр тутам илгээх;
- 4.8. Иргэдийн дундах аман яриа, төсөөллийг тогтмол тандах;

- 4.9. Иргэд, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны гарын авлагыг боловсруулах, хэвлүүлэх, түгээх;
- 4.10. Сургамж, дүгнэлт, санал бүхий тайлан гаргаж, 7 хоног бүр менежерт хүргүүлэх;

Тав. Санхүү, нөөцийн багийн ажиллах чиг үүрэг:

- 5.1. Үүсэн нөхцөл байдалтай холбоотой зардлын тооцоог гаргах, тодотгох, хуваарийн дагуу нөөцийг хангах, орон нутгаас нөөц бүрдүүлэлт хийх;
- 5.2. Урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй арга хэмжээнд шаардагдах нөөцийн тооцоог хийж, бэлэн байдлыг хангах;
- 5.3. Багуудын болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний ажилласан цагийн бүртгэлд үндэслэн цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал, илүү цагийн хөлсийг тооцож олгох;
- 5.4. Нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тооцоог гаргаж, шийдвэрлүүлэх;
- 5.5. Шаардлагатай худалдан авалтыг хууль журмын дагуу шуурхай зохион байгуулах;
- 5.6. Эрүүл мэндийн байгууллагуудад нөөцийг түгээх, аюулгүй байдлыг хангах;
- 5.7. Албад болон мэргэжлийн ангиудыг шилжүүлэн ажиллуулах, нөхцөл байдлын өөрчлөлт орсон үед байр, хүнсний болон бусад шаардлагатай материалаар хангах;